



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/82

Арвайхээр

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.“б”, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.5.1.3 дугаартай “Боловсрол, соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл” (Өвөрхангай, Арвайхээр, Тарагт сум)–д зарцуулах төсөл арга хэмжээний тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/56 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл (Өвөрхангай, Арвайхээр, Тарагт сум)–д зарцуулах 500.000.000 (таван зуун сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100173

Аймгийн Засаг даргын 2020 оны 02
дугаар сарын 27-ны өдрийн 7/22 дугаар
захирамжийн хавсралт

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН
ТӨСВИЙН БАГЦАД БАТЛАГДСАН ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГАД ЭРХ ШИЛЖСЭН БОЛОВСРОЛ, СОЁЛ, СПОРТЫН САЛБАРЫН
ИХ ЗАСВАР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛ (ӨВӨРХАНГАЙ,
АРВАЙХЭЭР, ТАРАГТ СУМ) ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн хичээлийн байрны сантехникийн засвар	40,000.0
2	Арвайхээр сумын Мэргэд цогцолбор сургуулийн тоног төхөөрөмж	50,000.0
3	Арвайхээр сумын 4 дүгээр сургуулийн урлаг заал, хичээлийн байрын их засвар	30,000.0
4	Арвайхээр сумын "Тэмүүлэл-Эрдэм" сургуулийн их засвар	45,000.0
5	Арвайхээр, Тарагт сумдын Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамирын хэрэгсэл тоног төхөөрөмж	70,000.0
6	Тарагт сумын цэцэрлэгийн дээврийн их засвар	22,000.0
7	Тарагт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дээврийн их засвар	40,000.0
8	Арвайхээр сумын 1 дүгээр цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж	5,000.0
9	Арвайхээр сумын 3 дугаар цэцэрлэгийн гадна тохижилт, тоглоомын талбай	10,000.0
10	Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн хэсэгчилсэн засвар	15,000.0
11	Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж	10,000.0
12	Арвайхээр сумын 6 дугаар цэцэрлэгийн аж ахуйн агуулах барих	5,000.0
13	Арвайхээр сумын 8 дугаар цэцэрлэгийн дулаан алдагдлыг багасгах засвар	15,000.0
14	Арвайхээр сумын 9 дүгээр цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж	8,000.0
15	Арвайхээр сумын 9 дүгээр цэцэрлэгийн дээвэр, гадна фасадын засвар	71,000.0
16	Арвайхээр сумын 11 дүгээр цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж	10,000.0
17	Арвайхээр сумын 12 дугаар цэцэрлэгийн хатуу, зөөлөн эдлэл	5,000.0
18	Арвайхээр сумын 13 дугаар цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж	21,000.0
19	Арвайхээр сумын "Мэргэд" цогцолбор сургуулийн дээврийн засвар	28,000.0
	НИЙТ ДҮН	500,000.0